

## МОНГОЛЫН НЭГЭН ШИЛДЭГ ЭРДЭМТЭН ФИЗИКЧИЙГ ДУРСАН САНАХ МИНЬ ҮҮ

*УИХ-ын гишүүн, академич Б. Чадраа*

Монгол туургатны дундаас товойн гарч гадаадын физикчдийн дунд нэрд гарсан, эх орондоо цөмийн физикийг хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан хүний нэг бол академич Намсрайн Содном гуай билээ.

Н.Содном гуайн монголын шинжлэх ухаанд, ялангуяа цөмийн физикийн судалгааг хөгжүүлэхэд оруулсан хувь хандив арвин их. Түүний эрдэм шинжилгээний ажил нь Ломносовын нэрэмжит Москвагийн их сургууль, Дубна дахь цөмийн шинжилгээний нэгдсэн институтэд ажиллаж байсан үеэс эхэлсэн гэж үздэг. Н.Содном гуайн 80 насны ойд зориулсан Олон улсын энэхүү эрдэм шинжилгээний бага хурал дээр түүний цөмийн физикийн салбарт хийж гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлын талаар гадаад, дотоодын олон хүн илтгэл тавих тул энэ чиглэлийг дурдалгүйгээр Н.Содном гуайн цөмийн физикийг монголд хөгжүүлэх ажлыг зохион байгуулах талаар хийж гүйцэтгэсэн нөр их хөдөлмөр зүтгэлийн талаар өөрийн мэдэх заримыг энд дурдахыг хүсч байна.

Тэрээр олон улсын цөмийн физикийн нэгдсэн институтыг байгуулахад Монгол улсыг төлөөлж идэвхтэй оролцсон билээ. Энэ үеэс эхлэн эх орондоо цөмийн физикийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулж эхэлсэн юм. ЦШНИ дэх Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч, эрдмийн зөвлөлийн гишүүний хувьд олон тооны залуу физикчдийг монголоос ажиллуулах тэдгээрийг хожим эх орондоо хэрэгтэй чиглэлээр эрдэм шинжилгээний ажлыг хийлгэхэд илүү анхаарч ажиллажээ. Түүний нэг жишээ нь нейтроны генератор хэмээх цөмийн төхөөрөмжийг монголд байгуулах талаар хүчин чармайлт гаргаж байсныг өөрийн биеэр үзсэн хүний нэг бол би юм. Тэр үед миний бие Дубна дахь нутгийн зөвлөлийн асуудлыг эрхэлж байсны хувьд монголоос Н.Содном гуай янз бүрийн даалгавар, зөвлөлгөө утсаар өгч, түүний дагуу уг төхөөрөмжийг Дубнагаас монгол руу ачуулсан юм. Содном багш нейтроны генераторыг монгол улс үнэгүй авах зөвшөөрлийг авахуулахтай холбогдсон бичиг баримт бүрдүүлэх зэрэг олон төрлийн арга хэмжээ авах, Монголд суурилуулах, ажиллуулах зэрэг ихээхэн бэрхшээлтэй ажлуудыг хийж гүйцэтгэсэн юм.

Чухамдаа энэхүү нарийн ажиллагаатай төхөөрөмжийг монголд байгуулсан нь бага энергийн физик хөгжих үндэс суурийг эх орондоо тавьсан гэж хэлж болно. Хожим нь дэлхийд нэртэй физикчидтэй зөвлөж ярилцаад, электроны хурдасгагч микротроп MT-22-ыг ШУА-ийн Физик техникийн хүрээлэнгийн дэргэд байгуулах зөвшөөрлийг Монгол Улсын Засгийн газраар гаргуулж ажиллуулах томоохон төслийг удирдан зохион байгуулсан хүн бол Н.Содном гуай юм. Энэ бүгд нь монгол улсад цөмийн судалгааны төв байгуулах бааз суурийг бий болгосон билээ. Тухайн үед цөмийн судалгааны төвийг байгуулах саналыг бид гарган тавьж байсан боловч түүнийг хэрэгжүүлэх зориг гаргах физикчид бараг үгүй байлаа. М.Энхсайханы засгийн газрын үед миний бие цөмийн физикийн үндэсний төвийг байгуулах саналыг оруулахад Н.Содном гуай сэтгэл санааны ихээхэн дэмжлэг үзүүлж байсныг өнөөдөр зориуд цохон тэмдэглэхийг хүсч байна.

Тэрээр амьдралынхаа сүүлийн жилүүдэд монголд атомын цахилгаан станц байгуулах саналыг нилээд шийдэмгий дэвшүүлж төвийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр бодлоо илэрхийлж байсныг бид мэдэх билээ. Энэ асуудлаар бид хоёр ОХУ-ын цөмийн эрчим хүчний яамтай хэлэлцээр хийхээр тохирч байсан боловч хэдхэн сарын өмнө таалал төгссөн юм. Энэ ажил өнөөдрийн байдлаар урагштай явж байгааг тэмдэглэхдээ баяртай байхын зэрэгцээ Н.Содном багшийн орон зай илт үгүйлэгдэж байгааг харамсан тэмдэглэхийг хүсч байна.

Н. Содном багш бол олон улсад нэрд гарсан томоохон физикч болохыг Женев хотод болсон Цөмийн эрчим хүчний олон улсын их хурал зэрэг олон улсын томоохон арга хэмжээнд хамт оролцож байсны хувьд сайн мэдэх болсон юм.

Н.Содном гуай шинжлэх ухааны олон чиглэлийн өргөн мэдлэг бүхий үндэсний томоохон сэхээтэн бөгөөд зах зээлийн үед шинжлэх ухааныг яаж хөгжүүлэх вэ? гэдэгт ихээхэн ач тусгагч өгсөнийг түүний орлогчоор олон жил ажилласны хувьд тод томруун мэдэх болсон юм.

Тэрээр монголын орчин үеийн физикчдийг хүмүүжүүлэн бий болгоход асар их хувь нэмэр хандив оруулсан юм. Эцэст нь түүний зочиломтгой гэр бүл, бүгдийн ээж, эгч болсон Цэрэндулам гуайгаар өнөөдөр бахархан дурсах нь зүйд нийцэх бөлгөө.